



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2022.02.25 № 483

танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Хотын стандарт хяналтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийслэлийн Хотын стандарт хяналтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хотын стандарт хяналтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2022/706/НА-СА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Улаанбаатар хот 2022 он</p>	<p>Аудитын хоёрдугаар хэлтсийн дарга, аудитын менежер: З.Мөнхбаяр Утас: 327734 Цахим хаяг: Munkhbayarz@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: С.Гантөгс Утас: 315558 Цахим хаяг: Gantugss@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Н.Баттогоо Утас: 325093 Цахим хаяг: Battogoon@audit.gov.mn</p> <p>Аудитор: Ж.Мөнхтуяа Утас: 325093 Цахим хаяг: Munkhtuyaja@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	14
3.10. ЗАВСРЫН АУДИТЫН ҮР ДҮН, ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Залруулсан алдаа	16
4.3 Зөвлөмж.....	Error! Bookmark not defined.
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
ЗГ	Засгийн газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББ	Нягтлан бодох бүртгэл

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>212,569,655.00</u>	<u>172,275,070.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	11,115,635.00	8,990,000.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	11,115,635.00	8,990,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	201,454,020.00	163,285,070.00
351	Түүхий эд материал	159,248,500.00	125,699,410.00
35110	Тусгай зориулалттай материал	159,248,500.00	125,699,410.00
354	Хангамжийн материал	42,205,520.00	37,585,660.00
35410	Бичиг хэргийн материал	14,241,300.00	4,568,250.00
35420	Аж ахуйн материал	10,391,100.00	10,422,790.00
35440	Түлш, шатах тослох материал	3,260,000.00	3,950,000.00
35470	Бусад хангамжийн материал	14,313,120.00	18,644,620.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>899,315,275.62</u>	<u>747,236,636.82</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	899,315,275.62	747,236,636.82
392	Биет хөрөнгө	334,726,108.22	278,969,058.74
39203	Авто-тээврийн хэрэгсэл	179,800,000.00	179,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(10,338,541.63)	(32,813,541.55)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	152,228,332.00	152,228,332.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(29,345,364.29)	(56,401,469.83)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	52,400,148.34	52,400,148.34
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,018,466.20)	(16,244,410.22)
393	Биет бус хөрөнгө	564,589,167.40	468,267,578.08
39301	Программ хангамж	1,430,000.00	1,430,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(714,999.96)	(1,191,666.60)
39303	Бусад биет бус хөрөнгө	564,860,834.00	564,860,834.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(986,666.64)	(96,831,589.32)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,111,884,930.62</u>	<u>919,511,706.82</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>11,115,635.00</u>	<u>8,990,000.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	11,115,635.00	8,990,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	11,115,635.00	8,990,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,100,769,295.62</u>	<u>910,521,706.82</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,100,769,295.62	910,521,706.82
512	Хуримтлагдсан үр дүн	1,100,769,295.62	910,521,706.82
51210	Өмнөх үеийн үр дүн	110,058,051.33	1,100,769,295.62
51220	Тайлант үеийн үр дүн	990,711,244.29	(190,247,588.80)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,111,884,930.62</u>	<u>919,511,706.82</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,026,398,334.34	947,273,690.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	70,531,534.34	218,090.00
120	Нийтлэг татварын бус орлого	70,531,534.34	218,090.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	218,090.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	16,400.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	201,690.00
120009	Бусад орлого	70,531,534.34	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	1,955,866,800.00	947,055,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,000,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,000,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,940,866,800.00	947,055,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,940,866,800.00	947,055,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,035,687,090.05	1,137,521,278.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,035,687,090.05	1,137,521,278.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	875,526,180.54	825,256,622.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	474,182,988.00	527,752,403.00
210101	Үндсэн цалин	391,468,926.45	377,701,377.19
210102	Нэмэгдэл	29,373,458.00	64,360,480.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,137,999.55	45,781,002.81
210104	Урамшуулал	37,202,604.00	39,909,543.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,484,109.64	69,203,689.87
210201	Тэтгэврийн даатгал	40,676,644.12	48,279,119.77
210202	Тэтгэмжийн даатгал	4,784,316.57	5,355,437.39
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,800,569.33	4,203,709.35
210204	Ажилгүйдлийн даатгал	868,029.56	1,033,221.54
210205	Эрүүл мэндийн даатгал	9,354,550.06	10,332,201.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	5,980,000.00
210304	Байрны түрээс	-	5,980,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	35,021,416.85	63,675,520.36
210401	Бичиг хэрэг	9,591,600.00	48,766,040.00
210402	Тээвэр, шатахуун	9,216,400.00	7,810,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,931,216.85	6,164,914.36
210404	Ном, хэвлэл	9,900,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	264,450.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	382,200.00	670,116.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	204,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	204,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	274,850,597.00	2,882,370.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	274,850,597.00	30,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	187,110.00

Хотын стандарт хяналтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан 9

210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	226,760.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	102,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	2,336,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,987,069.05	155,558,638.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	225,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	800,000.00	3,480,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	30,962,069.05	152,078,638.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	160,160,909.51	312,264,656.77
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,842,905.00	3,182,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,842,905.00	3,182,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	155,318,004.51	309,082,656.77
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	155,318,004.51	309,082,656.77
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	990,711,244.29	(190,247,588.80)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	990,711,244.29	(190,247,588.80)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	110,090,105.33	110,090,105.33
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(32,054.00)	(32,054.00)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	110,058,051.33	110,058,051.33
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	990,711,244.29	990,711,244.29
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	1,100,769,295.62	1,100,769,295.62
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	1,100,769,295.62	1,100,769,295.62
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	1,100,769,295.62	1,100,769,295.62
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(190,247,588.80)	(190,247,588.80)
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	910,521,706.82	910,521,706.82

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,966,982,435.00	947,072,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,115,635.00	16,400.00
120	Нийтлэг татварын бус орлого	11,115,635.00	16,400.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,115,635.00	16,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,115,635.00	16,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,955,866,800.00	947,055,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,000,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,000,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,940,866,800.00	947,055,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,940,866,800.00	947,055,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,198,885,361.00	947,072,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,198,885,361.00	947,072,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,038,724,451.49	634,807,343.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	474,170,656.00	527,752,403.00
210101	Үндсэн цалин	391,374,356.45	377,701,377.19
210102	Нэмэгдэл	29,468,028.00	65,112,738.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,125,667.55	45,015,499.81
210104	Урамшуулал	37,202,604.00	39,922,788.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,496,441.64	69,203,689.87
210201	Тэтгэврийн даатгал	42,996,916.60	48,279,119.77
210202	Тэтгэмжийн даатгал	3,926,392.57	5,355,437.39
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,404,959.33	4,203,709.35
210204	Ажилгүйдлийн даатгал	833,480.08	1,033,221.54
210205	Эрүүл мэндийн даатгал	8,334,693.06	10,332,201.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	5,980,000.00
210304	Байрны түрээс	-	5,980,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,280,456.85	21,154,960.36
210401	Бичиг хэрэг	5,555,200.00	5,220,000.00
210402	Тээвэр, шатахуун	7,066,400.00	8,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,926,856.85	6,164,914.36
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	270,350.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	732,000.00	999,696.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,398,000.00	3,953,920.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,398,000.00	3,953,920.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	479,678,897.00	3,282,370.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	479,678,897.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	-	187,110.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	226,760.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	102,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	2,766,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,700,000.00	3,480,000.00

Хотын стандарт хяналтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

12

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,700,000.00	3,480,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	160,160,909.51	312,264,656.77
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,842,905.00	3,182,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,842,905.00	3,182,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	155,318,004.51	309,082,656.77
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	155,318,004.51	309,082,656.77
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	768,097,074.00	=
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	756,981,439.00	2,125,635.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	756,981,439.00	2,125,635.00
2200	Дотоод эх үүсвэрээр	756,981,439.00	2,125,635.00
223001	Бусад хөрөнгө	-	2,125,635.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	756,981,439.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(756,981,439.00)	(2,125,635.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	11,115,635.00	(2,125,635.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	11,115,635.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	11,115,635.00	8,990,000.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	947,055,600.00	637,989,343.23	309,066,256.77	67.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	947,055,600.00	637,989,343.23	309,066,256.77	67.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	942,055,600.00	634,807,343.23	307,248,256.77	67.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	794,923,200.00	527,752,403.00	267,170,797.00	66.39
210101	Үндсэн цалин	562,849,200.00	377,701,377.19	185,147,822.81	67.11
210102	Нэмэгдэл	84,427,400.00	65,112,738.00	19,314,662.00	77.12
210103	Унаа хоолны хөнгөлөлт	72,600,000.00	45,015,499.81	27,584,500.19	62.00
210104	Урамшуулал	75,046,600.00	39,922,788.00	35,123,812.00	53.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	107,314,600.00	69,203,689.87	38,110,910.13	64.49
210201	Тэтгэврийн даатгал	75,517,700.00	48,279,119.77	27,238,580.23	63.93
210202	Тэтгэмжийн даатгал	7,949,200.00	5,355,437.39	2,593,762.61	67.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,359,400.00	4,203,709.35	2,155,690.65	66.10
210204	Ажилгүйдлийн даатгал	1,589,800.00	1,033,221.54	556,578.46	64.99

Хотын стандарт хяналтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

13

210205	Эрүүл мэндийн даатгал	15,898,500.00	10,332,201.82	5,566,298.18	64.99
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,000,000.00	5,980,000.00	20,000.00	99.67
210304	Байрны түрээс	6,000,000.00	5,980,000.00	20,000.00	99.67
2104	Хангамж, бараа материалын зардал	22,806,800.00	21,154,960.36	1,651,839.64	92.76
210401	Бичиг хэрэг	5,220,000.00	5,220,000.00	-	100.
210402	Тээвэр, шатахуун	8,506,800.00	8,500,000.00	6,800.00	99.92
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,440,000.00	6,164,914.36	1,275,085.64	82.86
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	640,000.00	270,350.00	369,650.00	42.24
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00	999,696.00	304.00	99.97
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,000,000.00	3,953,920.00	46,080.00	98.85
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,000,000.00	3,953,920.00	46,080.00	98.85
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,531,000.00	3,282,370.00	248,630.00	92.96
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	-	-	
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	187,110.00	112,890.00	62.37
210804	Тээврийн хэрэгслийн татвар	231,000.00	226,760.00	4,240.00	98.16
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	200,000.00	102,500.00	97,500.00	51.25
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,800,000.00	2,766,000.00	34,000.00	98.79
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,480,000.00	3,480,000.00	-	100.
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,480,000.00	3,480,000.00	-	100.
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,000,000.00	3,182,000.00	1,818,000.00	63.64
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,000,000.00	3,182,000.00	1,818,000.00	63.64
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,000,000.00	3,182,000.00	1,818,000.00	63.64
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	16,400.00	(16,400.00)	
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	947,055,600.00	637,972,943.23	309,082,656.77	67.36
132001	Орон нутгийн төсвөөс	947,055,600.00	637,972,943.23	309,082,656.77	67.36
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	16,400.00	(16,400.00)	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	16,400.00	(16,400.00)	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	60.00	40.00	20.00	66.67
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	59.00	39.00	20.00	66.10

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1. “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Нийслэлийн Хотын стандарт хяналтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг НТАГ-ын аудитын хоёрдугаар хэлтсийн аудитор Ж.Мөнхтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер С.Гантөгс, хэлтсийн дарга, аудитын менежер З.Мөнхбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Эрдэнэжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийслэлийн Хотын стандарт хяналтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг НТАГ-т 2022 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 20 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Нийслэлийн Нийслэлийн Хотын стандарт хяналтын газрын үйл ажиллагааны чиг үүргийг “Засгийн газрын болон Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Улаанбаатар хотын цаашдын хөгжлийг хангах тогтвортой хөгжлийн зорилтыг биелүүлж, иргэдийн амьдрах орчны ая тух, аюулгүй байдлыг хангасан хот болон хөгжихөд хотын стандартын баримт бичгийг боловсруулж, олон улсын чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлж ажиллах” гэж тодорхойлсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар, түүний дотор дотоод аудиторын тайлант оны ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаар: Тус байгууллагын 2019-2020 оны үйл ажиллагаанд Нийслэлийн Дотоод аудитын албанаас аудит хийж 3 зөвлөмж өгснийг тайлант онд хэрэгжүүлж ажилласан байна. Тухайлбал, ажилтнуудад

үр дүнгийн урамшууллыг хагас бүтэн жилээр олгосон, байгууллагын гэрчилгээг Төрийн өмчит үйлдвэрийн газар байсныг төрийн байгууллага болгож өөрчилсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийслэлийн Хотын стандарт хяналтын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккурэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 1,035,687.0 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 20,713.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80.0 хувиар буюу 16,570.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Нийслэлийн Хотын стандарт хяналтын газрын 2021 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 192,373.0 мянган төгрөгөөр буюу 17,3% хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1

Мөнгөн хөрөнгө	11,115.6	8,990.0	2,125.6
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	201,454.02	163,285.07	(38,168.0)
Үндсэн хөрөнгө	899,315.28	747,236.64	(152,078.64)
Нийт хөрөнгө	1,111,884.93	919,511.70	(192,373.0)
Өр төлбөр		-	
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,111,884.93	919,511.70	(192,373.0)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,111,884.93	919,511.70	(192,373.0)

Мөнгөн хөрөнгө дансны 8,990.0 мянган төгрөгийн үлдэгдэл “Монгол хьюндай автоматив” ХХК-д олгох барьцаа хөрөнгийн өглөг байна.

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 201,454.02 мянган төгрөгөөс 163,285.07 мянган төгрөг болж буурсан байна. Үүнд өмнөх оны тусгай зориулалтын материалын дансанд бүртгэлтэй 159,248.5 мянган төгрөгийн стандартын материалаас тайлант онд 33,549.0 мянган төгрөгийн зарлагадаж оны эцэст 125,699.4 мянган төгрөгийн их хэмжээний материалын үлдэгдэлтэй байна. Бусад хангамжийн материалын дансанд 8,950.0 мянган төгрөгийн видео контент, 3,600.0 мянган төгрөгийн ажилтнуудын нормын хувцасны үлдэгдэл байна. Түлш шатах тослох материалын дансанд 3,950.0 мянган төгрөгийн шатахууны 3 сарын нөөц үүсгэсэн байна. Бусад хангамжийн материалын дансанд 18,644.6 мянга, бичиг хэргийн материалын дансанд 4,173.0 мянган төгрөгийн үзэг дэвтрийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 747,236.64 мянган төгрөг болж 152,078.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд байгуулсан элэгдлийн зардал байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,019,910.4 мянган төгрөгөөр буюу 52 хувиар буурсан нь урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн бууралт байна.

Нийт зардал өмнөх оноос 251,813.4 мянган төгрөгөөр буюу 22 хувиар буурсан нь урсгал үйл ажиллагааны санхүүжилт буурсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Хотын стандарт орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газрын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,854,734.5 мянган төгрөгөөр тооцож дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 1,907,678.0 мянган төгрөгөөр бууруулж 947,055.6 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд, Цалин хөлс болон нэмэгдэл урамшил 31,127.90, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 4,202.30 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 30,628.20 мянга, эд хогшил, урсгал засварын зардлыг 189,996.50 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн

ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 1,508,424.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 107,800.0 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 5,000.0 мянган төгрөгөөр тус тус бууруулжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 19 арга хэмжээнд 947,055.6 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 947,055.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны орлогоор 16.4 мянган төгрөг орж, үйл ажиллагааны зардалд 637,989.3 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 309,082.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 637,989.3 мянган төгрөг буюу 67.4 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 305,281.7 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 1,651.8 мянган төгрөгөөр, эд хогшил худалдан авах зардлыг 48.1 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 248.6 мянган төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгийн зардлыг 1,818.0 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилт аваагүй, нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Бусад асуудлын хэсэг:

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд төсвийн орлого бүрдүүлэх 29 зорилтын хүрээнд 65 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 96.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан

болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

3.8 Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 20 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш 70,871.3 мянган төгрөгийн орлогын хоёр гүйлгээ, хөрөнгө захиран зарцуулсан 33,547.3 мянган төгрөгийн 13 шийдвэрийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 5.5."Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны цэс нь энэ хуулийн 3.2-т заасан ангиллыг баримталсан байх бөгөөд мэдээллийг бүрэн тусгасан байна" заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

- Алба хаагчдад 3,600.0 мянган төгрөгийн албаны ажлын хувцас худалдан авсан нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.4. "Энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, цаг үеийн шинж чанартай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх албан шаардлага өгсөн.

- Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас (цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, ашиглалтын зардал) бусад төрлийн зардлаас 1,661.3 мянган төгрөгийг дутуу хэмнэсэн нь 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, цаг үеийн шинж чанартай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх албан шаардлага өгсөн.

Тайлант онд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авалт хийгдээгүй байна.

3.10. ЗАВСРЫН АУДИТЫН ҮР ДҮН, ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

3.10.1. Завсрын аудитын үр дүн:

2021 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна. Тухайлбал: Байгууллагын ажилтнуудын эд хариуцагчийн картыг хөрөнгийн нэр төрлөөр нь картад бүртгэсэн байна.

3.10.2. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 10,616.0 мянган төгрөгийн зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		/мянган төгрөг/ Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	10,616.0	3	10,616.0	-	-	-
Нийт дүн	3	10,616.0	3	10,616.0	-	-	-

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар байгууллагын тусгай зориулалтын материалын үлдэгдлийн зарцуулалт, төсвийн төлөвлөлт, үндсэн хөрөнгийн ашиглалтыг үзэх болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 121,202.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 110,058.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 11,144.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

- Санхүүгийн байдлын тайланд өмнөх оны 110,058.0 мянган төгрөгийн өмнөх үеийн үр дүнг зөрүүтэй илэрхийлсэн.

4.2.1 Зардлын данстай холбоотой асуудал:

1.1. Илрүүлэлт: Тайлант онд байгууллагын дансанд бүртгэлтэй 2 авто тээврийн хэрэгслийн дулаан зогсоолын түрээсийн төлбөр 4,300.0 мянган төгрөг урьдчилж төлснийг тайлант оны зардлаар хүлээн зөвшөөрч тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4. "үнэн зөв байх", 6.1. "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө" заалтуудыг тус тус зөрчсөн байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 6.1 заалтуудыг мөрдөж ажиллах зөвлөмж өгөв.

2.1 Илрүүлэлт: Жолоочийн тооцооны хуудсыг хянаж 2,720.0 мянган төгрөгийн шатахууны зардлын тооцоог бодоогүй нь Сангийн сайдын 2017 оны 347-р тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 5.4 "Тухайн байгууллагын хөнгөн тэрэг нь ямар албан тушаалтны хэрэгцээнд үйлчилсэн талаархи гүйцэтгэлийг гаргахдаа жолоочийн тооцооны хуудсыг хэрэглэнэ. Хөнгөн тэрэг хэрэглэсэн албан тушаалтан хэдэн км явснаа хянаад гарын үсэг зурна. Тооцоог нягтлан бодогч хийж, нийт дүнгээр түлш, шатахууны хэмнэлт, хэтрэлтийг гаргана" заалтыг зөрчсөн байна

2.2 Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2017 оны 347-р тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 5.4 дэх заалтыг мөрдөж ажиллах зөвлөмж өгөв.

4.2.2 Бараа материалын данстай холбоотой асуудал:

1.1 Илрүүлэлт: Алба хаагчдын нормын хувцсыг 2 өөр дансанд ангилан бүртгэсэн нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 4.16 "Бараа материал болон үндсэн хөрөнгийг ангилж бүртгэхдээ дансны нэгдсэн жагсаалт болон холбогдох УСНББОУС-ыг мөрдөнө" заалтыг хэрэгжүүлээгүй.

1.2 Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 4.16 заалтыг мөрдөж ажиллах зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Алдаа, зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал:											
1	Тайлант онд байгууллагын дансанд бүртгэлтэй 2 авто тээврийн хэрэгслийн дулаан зогсоолын түрээсийн төлбөр урьдчилж төлснийг тайлант оны зардлаар хүлээн зөвшөөрч тайлагнасан	1	4,300.0							1	4,300.0
2	Шатахууны тайлан гаргаж, тооцоог сар бүр хянаж бодоогүй	1	2,720.0							1	2,720.0
3	Алба хаагчдын нормын хувцсыг 2 өөр дансанд ангилан бүртгэсэн	1	4,124.0							1	4,124.0
4	Санхүүгийн байдлын тайланд өмнөх оны өмнөх үеийн үр дүнг зөрүүтэй илэрхийлсэн	1	110,058.0	1	110,058.0						
	Дүн	4	121,202.0	1	110,058.0					3	11,144.0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудал:											
1	Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлогын хоёр гүйлгээг 70,871.3 мянган төгрөгийн гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн, хөрөнгө захиран зарцуулсан 33,547.3 мянган төгрөгийн 13 шийдвэрийг хугацаа хоцроож мэдээлсэн	1	104,418.6							1	104,418.6
2	Алба хаагчдад 3600.0 мянган төгрөгийн албаны ажлын хувцас худалдан авсан	1	3,600.0					1	3,600.0		
3	Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас (цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, ашиглалтын зардал) бусад төрлийн зардлаас 1,661.3 мянган төгрөгийг дутуу хэмнэсэн	1	1,661.3					1	1,661.3		
	Дүн	3	109,679.9					2	5,261.3	1	104,418.6
	Нийт дүн	7	230,881.9	1	110,058.0			2	5,261.3	4	115,652.6



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2022.02.25 № 501
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН ХОТЫН СТАНДАРТ
ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГА
С.ТӨМӨРДУЛАМ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Хотын стандарт хяналтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд баталгаажуулах аудит хийлээ.

Аудитаар илэрсэн 5,261.3 мянган төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлж байна.

Албан шаардлагын биелэлтийг заасан хугацаанд хэрэгжүүлж, хариу ирүүлнэ үү.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

002032669



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 134/А0270187

Улаанбаатар хот

НААГ-2022/706/НА-СА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Хотын стандарт хяналтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас (цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, ашиглалтын зардал) бусад төрлийн зардлаас 1,661,300.00 (нэг сая зургаан зуун жаран нэгэн мянга гурван зуун) төгрөгийг дутуу хэмнэсэн, алба хаагчдад 3,600,000.00 (гурван сая зургаан зуун мянган) төгрөгийн албаны ажлын хувцас худалдан авсан нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 "Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах", 1.4. "Энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." заалтуудыг үндэслэн ШААРДАХ нь:

1. Эрх бүхий дээд шатны байгууллагаас гарсан шийдвэрүүдийг мөрдөн ажиллаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 25-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, цаг үеийн шинж чанартай хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Хотын стандарт хяналтын газрын дарга С.Төмөрдулам, нягтлан бодогч Б.Түмэнжин нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ
ӨГСӨН:

АУДИТОР



Ж.МӨНХТУЯА

ХЯНАСАН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ХЭЛТСИЙН
ДАРГА, АУДИТЫН МЕНЕЖЕР



З.МӨНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР



С.ГАНТӨГС